


УУЛБАЯН СУМЫН 9-Р САРЫН МЭДЭЭ

2024-09-30

Зүүнбулаг

ТӨРИЙН УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР:

2024 оны 09 сарын 10-ны өдөр “Контекст Монгол групп” ХХК “Сургалтын байгууллага”-аас 2024 оны 09 сарын 15-ны өдрөөс 2024 оны 10 сарын 15-ны өдрүүдэд зохион байгуулах “Орон нутгийн захиргаанд ISO18091:2019 буюу орон нутгийн захиргаанд ISO9001:2015 чанарын менежментийн тогтолцооны стандарт хэрэгжүүлэх арга зүй”-н сургалтанд нийт 24 албан хаагчийг хамруулахаар харилцан тохиролцож гэрээ байгуулсны дагуу сургалтыг зохион байгууллаа



2024 оны 09 сарын 18-ны өдөр Алтан намар-2024 үзэсгэлэн худалдааг амжилттай зохион байгууллаа нийт 12 малчид худалдаа үйлдвэрлэл, эрхлэгчид өөрсдийн бүтээгдэхүүнээрээ оролцлоо.



Шилдэг сүү сүүн бүтээгдэхүүн, гар урлал, хүнсний ногооны чиглэлээр шагнал байрыг шалгаруулсан.





Шилдэг хүнсний ногоо: 1,2,3-р байр



Шилдэг гар урлалын бүтээгдэхүүн-1,2,3,4-р байр





Малчид үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ, мэдээллийг олон нийтэд танилцуулах, үйл ажиллагааг нь дэмжин хөгжүүлэх, борлуулалтыг нэмэгдүүлэх, харилцан туршлага солилцуулах, аймгийн шилдэг бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх зорилгоор “Намрын ногоон өдрүүд-Сүхбаатарт үйлдвэрлэв-2024 арга хэмжээний хүрээнд “Эрүүл хүнс, Алтан намар Хөнгөн үйлдвэрлэл үзэсгэлэн худалдаа 2024 оны 09 сарын 20,21-ний өдрүүдэд баруун-уртад зохион байгуулагдлаа.

Сумаас нийтдээ 7 баялаг бүтээгчид, эсгий эдлэл, хүнсний ногоо, сүү сүүн бүтээгдэхүүн, суран эдлэлийн чиглэлээр оролцлоо. Мөн “Шилдэг тариаланч” төрөлд шалгарлаа



